

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ”

АУДИТЫН КОД: ГСА-2023/12-6-НА-НА

Говьсүмбэр аймаг

2023 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМАТ	Ашигт малтмалын ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БХНСАХ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТБТ	Насан туршийн боловсролын төв
СДОА	Сум дундын ойн анги
ОАТ	Орлогын албан татвар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хурал
УССТ	Усан спорт сургалтын төв
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЦХБТАОАТ	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, МУЕА-ын 2023 оны А/04 дүгээр тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг гүйцэтгэсэн.Үүнд:

- Төсвийн төсөлд төсвийн орлогыг боломжит хэмжээнд нэмэгдүүлж төлөвлөсөн үү?
- Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж, санхүүжилтийг үр нөлөөтэй ТАХ-д зарцуулахаар төлөвлөсөн үү?

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Татварын хуулиуд
- ✓ Засгийн газрын 2019 оны 312, 2021 оны 160 дугаар тогтоол
- ✓ Сангийн сайдын 2019 оны А/282, 2021 оны А/86 дугаар тушаал
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, гэрээ, эрх зүйн актууд
- ✓ Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох шаардлагатай хууль, дүрэм, журам

Аудитын хамарсан
хүрээ:

Аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан орон нутгийн 2024 оны төсвийн төсөл, түүний орлого, зарлагын тооцоо судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн баримт материал, аймгийн ЗДТГ болон төсвийн төлөвлөлтөд оролцсон бусад байгууллагыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэсэн.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон Засаг даргад 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл:

Хүндрэл бэрхшээл байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “..., түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасан бүрэн эрхийн дагуу аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулан хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль хэлэлцэн баталсан.

Аймгийн Засаг даргаас орон нутгийн 2024 оны төсвийн төслийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр А/1452 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 24,875.7 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь орлогыг 11,382.4 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 6,704.8 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 6,788.5 сая төгрөг байна.

Мөн зарлагыг 24,875.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүний 73 хувийг төсвийн суурь зарлага эзэлж байна.

- ❖ Төсвийн суурь зарлагыг 18,170.9 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 6,704.8 сая

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн харьцуулалт	7
Дүрслэл 2	Орлогын төлөвлөгөөний харьцуулалт	7
Дүрслэл 3	Татварын болон татварын бус орлогын харьцаа	8
Дүрслэл 4	Нэмэгдүүлсэн орлогын нэр төрөл	9

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 2024 оны суурь орлогын саналыг Сангийн яамны хянасан суурь орлоготой харьцуулалт	7
Хүснэгт 2	Татварын болон татварын бус орлогын харьцаа	8
Хүснэгт 3	Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны баталсан доод хязгаартай харьцуулсан харьцуулалт	9
Хүснэгт 4	2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 5	Аймгийн 2024 оны төсвийн зарлага	12
Хүснэгт 6	2024 оны орон нутгийн төсвийн нийт зарлагад оруулсан өөрчлөлт	12
Хүснэгт 7	“Аймгийн 2024 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	14
Хүснэгт 8	Төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй 4 хөрөнгө оруулалт, арга хэмжээ”	14-15
Хүснэгт 9	Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”	15
Хүснэгт 10	Гэрээ байгуулснаас хойш 2-3 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт	15-16
Хүснэгт 11	БНАТ-ийн орлогын 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн БХНСАХЗ-ын тооцоолол	17

БҮЛЭГ 1**Төсвийн төсөлд төсвийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөх боломжтой байна.****1.1 Нийт орлогын дүнд эзлэх татварын ачаалал жил ирэх бүр нэмэгдсээр байна.**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 24,875.7 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:


- ❖ Төсвийн суурь орлогыг 11,382.4 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 6,704.8 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 6,788.5 сая төгрөг байна.

Мөн зарлагыг 24,875.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүний 73 хувийг төсвийн суурь зарлага эзэлж байна.

- ❖ Төсвийн суурь зарлагыг 18,170.9 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 6,704.8 сая

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 2023 онтой харьцуулж харуулбал:

Дүрслэл №1 Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн харьцуулалт



Дүрслэлээс харахад: Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх онтой харьцуулахад улсын 2.8 дахин, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 17%-иар тус тус өссөн байна.

Эх сурвалж: Аймгийн CTCX-ээс ирүүлсэн 2024 төсвийн төслийн баримт бичиг

2024 оны төсвийн төсөлд орлогын талаар дараах 4 чиглэлийг баримталж ажиллахаар тусгасан байна. Тухайлбал:

Дүрслэл №2. Орлогын талаар баримтлах чиглэлүүд

Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах

Татварын ерөнхий хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улсын төсвийн санхүүжилтээс татварын өрд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д “аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасан Сангийн яам хянасан орлогыг нэмэгдүүлэхгүй байх

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс ирүүлсэн 2024 төсвийн төслийн баримт бичиг

Аймгийн 2024 оны суурь орлогын саналыг Сангийн яамны хянасан суурь орлоготой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1

(сая. төг)

Орлогын нэр төрөл	Аймгийн 2024 оны суурь орлогын санал	Сангийн яамны хянасан суурь орлогын дүн	Зөрүү
	1	2	3-2-1
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	5,950.0	7,500.0	1,550.0
Үйл ажиллагааны орлого	50.0	50.0	-
Хөрөнгийн орлого	250.0	300.0	50.0
Хөрөнгийн борлуулсны орлого	100.0	150.0	50.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-400.0	-400.0	-
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	400.0	600.0	200.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	817.3	820.0	2.7
Бууны албан татвар	5.0	5.0	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	145.0	150.0	5.0
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	101.8	21.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	21.0	21.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	185.0	190.0	5.0
Газрын төлбөр	499.9	520.0	20.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	400.0	450.0	50.0
Нийт татварын орлогын дүн	8,638.2	10,457.8	1,819.6
Торгуулийн орлого	550.0	850.0	300.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	19.7	20.7	0.9
Түрээсийн орлого	54.0	54.0	-
Нийт татварын бус орлогын дүн	623.7	924.7	301.0
Суурь орлогын нийт дүн	9,261.9	11,382.5	2,120.6


Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс ирүүлсэн 2024 төсвийн баримт бичиг

Хүснэгтээс харахад: Сангийн яам нь аймгийн ирүүлсэн татварын суурь орлогын саналыг 21.0%-иар буюу 1,819.6 сая, нийт 10 нэр төрлийн татварын орлогыг 2.7-1,550.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 10,457.8 сая төгрөгөөр баталсан байна.

Тухайлбал, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 2024 оны 4 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг инфляц болон бусад эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулан тус тус нэмэгдүүлсэн байна.

Татварын бус орлогыг 48.3%-иар буюу 301.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 924.7 сая төгрөгөөр баталсан байна.

Дүрслэл №3. Татварын болон татварын бус орлогын харьцаа (сая.төг)



Эх сурвалж: Аймгийн ЗД-ын 2020-2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дүрслэлээс харахад: Нийт орлогын дүнд эзлэх татварын бус орлогын дүн 2021 оноос эхлэн 2.1-6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Сангийн яам орлогын төлөвлөлтөөр татварын ачааллыг жил ирэх бүр нэмэгдүүлж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр татварын хамрагдалт, татварын бааз суурийг өргөжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

1.2 Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн 2024 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг **11,382.5 сая** төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн Засаг даргаас 2024 оны төсвийн төсөлд орлогын эх үүсвэрийг **3,014.8 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, **14,397.3 сая** төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна. Орлогын эх үүсвэрийг дараах байдлаар нэмэгдүүлэн төлөвлөжээ. Үүнд:

1. Суурь орлого: Нийт 865.0 сая

- ❖ Татварын орлого-720.0 сая
- ❖ Татварын бус орлого-145.0 сая

2. Бусад орлого: Нийт 2,149.8 сая

- ❖ Аймаг, сумдын 2023 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал – 1,070.0 сая
- ❖ ОНХС, ОНХО-ын он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс – 1,079.8 сая /ОНХО-178.0 сая, АОНХС-901.8 сая /

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны баталсан доод хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №2 (сая.төг)

№	Орлогын нэр төрөл	Сангийн яам хянасан	2024 оны төсөв	Зөрүү
1	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	11,382.5	12,247.5	865.0
2	ТАТВАРЫН ОРЛОГО	10,457.8	11,177.8	720.0
3	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	924.7	1,069.7	145.0

Хүснэгтээс харахад 2024 оны төсөвт татварын орлогыг 720.0 сая, татварын бус орлогыг 145.0 сая, нийт 865.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Дүрслэл №4. Нэмэгдүүлсэн орлогыг нэр, төрлөөр нь харуулбал

Татварын орлого	Татварын бус орлого
- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого-420.0 сая - Дуудлага худалдааны орлого-300.0 сая	- Торгуулийн орлого-80.0 сая - Төсөвт байгууллагын өөрийн орлого-65.0 сая / Авто замын сан 20.0 сая, УССТ 20.0 сая, СДОА 20.0 сая, нийтийн тээвэр 5.0 сая /

Аймгийн СТСХ-ээс нэмэгдүүлсэн орлогын талаар тодруулахад дараах тайлбарыг ирүүлсэн байна.

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 2024 оны 04 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалин нэмэгдэхтэй холбогдуулан нэмсэн
- Торгуулийн орлого, дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурласан
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг тухайн байгууллагуудын ирүүлсэн саналд үндэслэсэн

Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ огт хийгээгүй байна. Дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлсэн нь орлогын төлөвлөгөө биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Хүснэгт №3 2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (10 дугаар сарын 31-ний байдлаар)

сая.төг

Орлогын нэр төрөл	2023 оны орлогын батлагдсан дүн	2023 оны 10 дугаар сарын орлогын төлөвлөгөө	2023 оны 10 дугаар сарын гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	5,794.7	4,831.1	5,710.0	118%
Үйл ажиллагааны орлого	50.0	40.8	76.5	187%
Хөрөнгийн орлого	250.0	208.1	236.5	114%
Хөрөнгө борлуулсны орлого	100.0	83.2	155.1	187%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-317.9	-317.9	-317.9	100%
Малын тоо, толгойд ногдох албан татвар	148.8	120.8	66.1	55%
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	300.0	220.0	300.0	136%
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	801.3	607.0	538.1	89%
Бууны албан татвар	5.0	4.1	2.8	68%
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	140.0	130.0	121.6	94%
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	65.8	106.9	163%
Газрын төлбөр	499.9	374.8	295.8	79%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	16.5	33.2	201%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	185.0	153.3	115.9	76%
Дуудлага худалдааны орлого	400.0	318.0	337.0	106%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0	40.0	55.5	139%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	787.0	687.0	636.9	93%

Түрээсийн орлого	60.0	50.0	34.0	68%
Хүү, торгуулийн орлого	900.0	781.8	965.3	123%

Хүснэгтээс харахад: Малын тоо, толгойд ногдох албан татвар, бууны албан татвар, түрээсийн орлогын гүйцэтгэл 55-68%-тай байна. 2021-2022 онд бууны албан татвар 4.1-7.2%, түрээсийн төлбөр 16.2-30%, малд ногдуулах албан татвар 2022 онд 51.5%-аар тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь жилийн эцсээр орлогын төлөвлөгөө татварын нэр, төрлөөр биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Татварын бус орлогыг нэмэгдүүлэх санал:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2¹, 28 дугаар зүйлийн 28.5², Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу аймгийн ИТХ хуулиар олгогдсон эрх үүргийнхээ хүрээнд түрээсийн төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулж, шинэчлэн тогтоох боломж байна. Уг тогтоолоор түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг баталсан бөгөөд аймгийн хэмжээнд орон сууцны түрээсийн хувьд зах зээлийн үнээс 11 дахин бага үнээр түрээсэлж байгаа бөгөөд метр квадратыг аймгийн төвд 5000, сумын төвд 3000 төгрөгөөр шинэчлэн тогтооход **69.7 сая**, ААНБ-ын түрээсийн хувьд метр квадратыг аймгийн төвд 7000, сумын төвд 3000 төгрөгөөр шинэчлэн тогтооход **46.3 сая**, нийт **116.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой.

Аудитаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2³, 6 дугаар зүйлийн 6.2.2⁴, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит, тооцоо судалгаанд тулгуурлах, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийх шаардлагатай
- Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1⁵, 6 дугаар зүйлийн 6.2.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1⁶-г зааснаар жил бүр тасарч буй татварын болон татварын бус орлогын шалтгаан нөхцөлийг тодруулж дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, татварын ногдол, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах шаардлагатай байна.

¹ 11.2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах

² 282 5. Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

³ 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

⁴ 6.2.2.жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;

⁵ 5.1.1.төсвийн тогтвортой байдлыг хангасан байх;

⁶ 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

БҮЛЭГ 2

Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж төлөвлөөгүй, зарим төсөл, арга хэмжээ холбогдох хууль тогтоомжийн шалгуурыг хангаагүй байна.

2.1 Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, ИТХ-аар батлуулаагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-т “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”, 18.6-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасан.

Аймгийн ЗДТГ-аас 2024 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг хуулийн хугацаанд багтааж, аймгийн ИТХ-д өргөн барьж батлуулаагүй байна.

ТЕЗ бөгөөд аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан төсвийн төсөлд тусгасан арга хэмжээнүүд нь аймгийн дунд, богино хугацааны (төсөл хэлбэрээр өргөн барьсан) бодлогын баримт бичигт агуулгын хувьд нийцэж байгаа боловч зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт нь оновчтой бус байна.

Цаашид хөрөнгө оруулалтын арга хэмжээний бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг хуулийн хугацаанд хийж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тогтоох шаардлагатай байна.

Аймгийн 2024 оны төсвийн нийт зарлага 24,875.7 сая төгрөгөөр хянагдан батлагдаж ирсэн байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь зарлагыг 18,170.9 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 6,704.8 сая

УИХ-аас батлагдаж ирсэн 24,875.7 сая төгрөгийн төсвийн зарлагыг ТЕЗ-аас 3,014.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 27,890.5 сая төгрөгөөр батлуулахаар төсвийн төслийг бэлтгэн ирүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын бүтцийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

“Аймгийн 2024 оны төсвийн зарлага”

(сая.төг)

Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2023 оны төсвийн төсөл	Зөрүү
Орон нутгийн суурь зардал	18,170.9	18,926.0	755.1
ОНХС-гийн зардал	6,704.8	7,606.5	901.8
ОНХО-ын зардал		1,358.0	1,358.0
Нийт дүн	24,875.7	27,890.5	3,014.8

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын өргөн барьсан төсөв, Сангийн яамнаас ирүүлсэн суурь зардлын төлөвлөгөө)

Аймгийн СТСХ-ээс 2024 оны орон нутгийн төсвийн нийт зарлагад дараах байдлаар өөрчлөлт оруулан төлөвлөж, санал ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 6

(сая.төг)

Байгууллагын нэр		Нэмсэн	Хассан	Зөрүү
Төсвийн байгууллагуудын зардал зарлага	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	299.0		299.0
	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	25.6		25.6
	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	509.0	1,057.2	- 548.1
	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалт /ОН-ОН/		600.0	- 600.0
	Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	164.0	56.7	107.3
	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	37.1	25.2	11.9
	Цөм сүргийн хөгжлийн төв	50.2	26.6	23.7
	Орон нутгийн өмчийн газар		35.4	- 35.4
	Худалдан авах ажиллагааны газар	255.1		255.1
	Мал эмнэлгийн зардал	0.1		0.1
	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас		4.9	- 4.9
	Ахмадын хороо	14.5		14.5
	Ойн анги	74.1	1.8	72.4
	Биений тамир /Усан спорт/	182.8		182.8
	Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	97.5		97.5
	Улсын төсвийн байгууллагын ТЗ-ны албан хаагч нарт ОНН-20 хувь	665.0		665.0
	Дүн	2,374.1	1,807.7	566.4
Хөрөнгө оруулалт, арга хэмжээний зардал	АИТХ-ГХУСАХЗ (Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал)	305.3		305.3
	АЗДТГ-Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагаа	700.0		700.0
	АЗДТГ-Орон нутгийн нөөц хөрөнгө	110.6		110.6
	Орон нутгийн хөрөнгө оруулалт	628.2		628.2
	Авто замын сан		252.0	- 252.0
	Аймгийн халамжийн сан	0.002		0.0
	БОАЖГ-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	54.5		54.5
	Орон нутгийн хөгжлийн сан	901.8		
Дүн		2,700.4	252.0	2,448.4
Нийт		5,074.5	2,059.7	3,014.8

(Эх сурвалж: Аймгийн CTCX-ээс ирүүлсэн мэдээлэл, түүнд хийсэн аудитын тулган баталгаажуулалтын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: Төсвийн байгууллагуудын суурь зардалд 2,374.1 сая төгрөгийг нэмж 1,807.7 сая төгрөгийг хасаж төсвийн зохицуулалтыг хийсэн байна. Нэмсэн зардлын 1,551.8 сая төгрөг буюу 65 хувийг цалингийн нэмэгдэл, 822.3 сая буюу 35 хувийг бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Орон нутгийн 2024 оны төсөвт тусгагдсан хууль дүрэм, журамд нийцээгүй нийт **78.0 сая** төгрөгийн зарлагыг бууруулах, хууль тогтоомжид нийцүүлэх дараах саналыг гаргаж байна.

Төсвийн зарлагыг бууруулах санал:

1. Аймгийн ИТХУрал

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1⁷, 31.1.3⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3⁹, Засгийн газрын 2019 оны 445-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын 3.4.4¹⁰-т заасны дагуу төлөвлөөгүй 14.0 сая төгрөгийн тээвэр шатахуун, хууль журамд төсөв захиран зарцуулах эрх олгоогүй 45.0 сая төгрөгийн аймгийн иргэдийн

⁷ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁸ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

⁹ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

¹⁰ тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

төлөөлөгчдийн хурлын даргын нөөц сан, нийт 59.0 сая төгрөгийн зардлыг бууруулах

2. Аймгийн ЗДТГазар

- Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төсвийн тухай хуулийн 24.7¹¹ дахь заалтаар хориглосон тэмдэглэлт өдрүүдэд зориулж 19.0 сая төгрөгийн төсөв зарцуулах үйл ажиллагаа төлөвлөсөн тул зардлыг бууруулах

2.2 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Говьсүмбэр аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд ОНХО, ОНХС, Авто замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх нийт 5,392.7 сая төгрөгийн 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ТЕЗ-аас хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхдээ 2024 оны орлого нэмэгдүүлэх эх үүсвэрээс 504.7 сая, 2023 оны ОНХО-ын он дамжих ажил 178.0 сая, ОНХС-ийн шилжих ажил 7.9 сая, хэмнэлт 893.9 сая төгрөг, нийт 1,584.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Авто замын санг 252.0 сая төгрөгөөр бууруулан, нийт 1,332.5 сая төгрөгөөр өөрчлөлт оруулж, батлуулахаар санал оруулсан байна.

Хүснэгт №7

“Аймгийн 2024 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”

(сая.төг)

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Авто замын сан	БХНСАХ	Нийт
1	Хөрөнгө оруулалт	1,550.4	375.0	302.9	50.0	2,278.3
2	Их засвар	681.0	403.0			1,084.0
3	Тоног төхөөрөмж	178.3	315.0			493.3
4	Зураг төсөв	315.4	87.0			402.4
5	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	532.0	-	259.3	157.5	948.8
6	Шилжих хөрөнгө оруулалт	7.9	178.0			185.9
	Дүн	3,265.0	1,358.0	562.2	207.5	5,392.7

Хүснэгтээс харахад: Нийт санхүүжүүлэхээр тооцсон төсөвт өртгийн 2,228.3 сая төгрөг буюу **41 хувийг** хөрөнгө оруулалтын ажилд зарцуулахаар төлөвлөжээ. Өмнөх онд нийт төсвийн **78 хувийг** хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг сайжруулах санал:

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ: Орон нутгийн хөгжлийн сан

Улсын Их Хурлаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 6,704.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс сумдад 4,341.5 сая төгрөгийг хуваарилж, 2,363.2 сая төгрөгөөр аймгийн ОНХС-г баталсан байна.

¹¹ Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөг, ойн баярт зориулж зарцуулахыг хориглоно.

Аймгийн ОНХС-д 2024 онд шилжих ажил 7.9 сая, 2023 онд хийгдээгүй ажлын 802.3 сая, гэрээний хэмнэлт 91.6 сая , нийт 901.8 сая төгрөгөөр эх үүсвэр нэмэгдэж, 3,265.0 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна. Эдгээр төлөвлөсөн ажлууд нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2024 оны жилийн төлөвлөгөө зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

2023 онд 3 хөрөнгө оруулалтын ажлаас үүссэн хэмнэлт нь бодит бус хэмнэлт буюу худалдан авах ажиллагаа амжилтгүй болсонтой холбоотойгоор үүссэн хэмнэлт байна.

Хүснэгт №8 “Төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй 3 хөрөнгө оруулалт, арга хэмжээ”

(сая.төг)				
№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Шалтгаан
1	Сүмбэр суманд нийтийн эзэмшлийн талбай, тохижилтын ажлууд	Барилга байгууламж	232.3	2023.10.09-нд 1 удаа нээлттэй тендер зарласан
2	Аймгийн төвд явган хүний замыг нэмэгдүүлэх ажил	Барилга байгууламж	70.0	2023.08.08-аас 2023.08.16-ны хооронд харьцуулалтын арга
3	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт утаагүй хог шатаах зуух худалдан авах	Тоног төхөөрөмж	500.0	2023.07.17, 2023.08.31-нд 2 удаа нээлттэй тендер зарласан
Нийт дүн			802.3	

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт, гүйцэтгэлийн судалгаа)

Төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь холбогдох эрх зүйн акттай нийцэж буй эсэхийг шалгахад дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын зөрчиж олон нийтийн саналаар эрэмбэлэгдээгүй 47.9 сая төгрөгийн арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт №9 “Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”

(сая.төг)			
№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	АЗДТГ-ын хурлын танхимд шаардлагатай тоног төхөөрөмж	27.5	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.5 ¹² , Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2 ¹³ , 4.7.5 ¹⁴ дахь заалтыг тус тус зөрчсөн.
2	ЭМГ-ын урсгал засварын зардал /хулдаас авах/	10.4	
3	УЦУОШТ-ийн цаг агаарт зориудаар нөлөөлөх, чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж	10.0	
Нийт		47.9	

Санал-Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж,орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцүүлэх

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ-Орон нутгийн хөрөнгө оруулалт

¹² 6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх;
¹³ 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;
¹⁴ 4.7.5.Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

2024 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 1,358.0 сая төгрөгийн 15 хөрөнгө оруулалт, арга хэмжээ төлөвлөжээ. Үүнээс: 178.0 сая төгрөгийн 5 арга хэмжээ нь 2021 оноос дамжсан байна.

Хүснэгт 10 Гэрээ байгуулснаас хойш 2-3 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт

(сая.төг)						
№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулснаас хойших хоног	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	2023-08-01	-116	198.0	158.4	39.6
2	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	2021-02-21	-1007	18.4	9.2	9.2
3	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	2022-07-18	-495	22.5	15.8	6.7
4	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	2022-12-01	-359	94.4	15.0	79.4
5	Шинээр баригдах Найрамдал хотхоны гадна цахилгаан хангамжийн 6 КВ-ын ЦДКШ дэд өртөөний ажил	2022-06-13	-530	240.9	197.7	43.2
Нийт			-2507	574.1	396.1	178.0

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт)

Хүснэгтээс харахад: 574.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан 5 хөрөнгө оруулалт, арга хэмжээний үлдэгдэл болох 178.0 сая төгрөгийн ажил 2024 онд дамжин хэрэгжихээр болсон байна. Цаашид төлөвлөсөн хугацаандаа багтаан ажлыг дуусган хүлээн авах, хугацаандаа үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож ажиллах шаардлагатай байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

Төрийн аудитын газраас 2022, 2023 онуудад Байгаль орчны салбартай холбоотой “Хог хаягдлын менежмент, түүний хэрэгжилт, үр дүн”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”, “Байгаль орчны мастер төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг гүйцэтгээд байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангаар дараах зөрчил илэрч зөвлөмж өгсөн. Үүнд:

Аймгийн СТСХ нь БОАЖГ-аас хүргүүлсэн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төсвийн төслийн саналыг хүлээн аваагүй, ирүүлсэн төслийн дүнд тооцоолол хийгээгүйгээс хуульд заасан БНАТ-ийн орлогын доод хувь хэмжээг баримтлаагүй зөрчил илэрсэн байна. Иймд СТСХ-т “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төсвийн төслийн саналыг хүлээн авах, төсвийн төслийг бодитой хянах зөвлөмжийг өгчээ.

БОАЖГ-аас 2023 оны 7 сарын 26-ны 275 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад 2024 онд БХНСАХЗ-аар хийх ажлын төлөвлөгөө, төсвийн тооцоог хүргүүлсэн боловч аймгийн СТСХ нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, уг саналд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Сангийн яамнаас боловсруулан гаргасан орон нутгийн 2024 оны төсвийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн 3 дугаар зүйлийн 3.5-т “Сангийн яам хянаж, Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан түвшнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсөвт тусгаж батлуулах, шаардлагатай бол орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс зардлыг нэмэгдүүлэх” гэж заасан.

Сангийн яамнаас 2024 оны орон нутгийн төсвийн суурь зарлагад тус арга хэмжээний зардлыг 231.0 сая төгрөгөөр хянасныг тэнцлийн ашгаас 54.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 285.5 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгажээ. Үүнээс аймагт 207.5 сая, Сүмбэр суманд 49.5 сая, Шивээговь суманд 25.8 сая, Баянтал суманд 2.7 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2024 онд шинээр хэрэгжүүлэх 1 хөрөнгө оруулалтын ажил, 9 төсөл, арга хэмжээнд нийт 207.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

СТСХ-ээс БХНСАХЗ-д 54.5 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн боловч энэ нь хуульд заасан доод хэмжээнд хүрэхгүй байна.

Хүснэгт: 11 БНАТ-ийн орлогын 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн БХНСАХЗ-ын тооцоолол

(сая. төг)

№	Орлогын төрөл	2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	Сангийн яамнаас хянаж ирсэн	Орон нутгаас нэмсэн	Нэмэгдүүлэх санал
1	Газрын төлбөр	499.9	75.0			
2	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	787.0	275.5	231.0	54.5	92.7
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	55.5	27.8			
	Нийт	1,342.4	378.2	231.0	54.5	92.7

(Эх сурвалж: Татварын хэлтсээс ирүүлсэн хүлээгдэж буй гүйцэтгэл, аудитын тооцоолол)

Хүснэгтээс харахад: БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасны дагуу доод хувь, хэмжээг баримтлан тооцоолол хийхэд нийт 378.2 сая төгрөгийг БХНСАХЗ-д тусгахаар байна.

Иймд Төрийн аудитын байгууллагаас гаргасан орлого нэмэгдүүлэх 116.0 сая, зардал бууруулах 78.0 сая, нийт 194.0 сая төгрөгийн саналаас БХНСАХЗ-ийг санхүүжүүлж, төсвийн төлөвлөлтийг хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан хариуцлага тооцуулах албан шаардлагад шилжих эрсдэлтэй болохыг анхааруулж байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 73 хувьтай байна.

2023 оны орон нутгийн төсвийн төслийн аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна.
Үүнд:

- Орон нутгийн өмчийн түрээсийн төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох, татварын суурийг нэмэгдүүлэх замаар орлого нэмэгдүүлэх санаачилга гаргах-хэрэгжилт 70 хувь

2. Төсвийн төсөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлэхдээ аливаа өөрчлөлтийг багтаасан эцсийн байдлаар бэлтгэсэн төсвийн төслийг ирүүлэх-100 хувь
3. Төсвийн төслийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах аргачлал-ын дагуу бэлтгэх-50 хувь

Гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг нэмэгдүүлэх 116.0 сая, зардлыг бууруулах 78.0 сая, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх 140.6 сая, нийт 334.6 сая төгрөгийн санал, 3 зөвлөмжийг гаргаж аймгийн ИТХ, ТЕЗ-д хүргүүлээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1: Төсвийн төсөлд төсвийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөх боломжтой байна

1. Нийт орлогын дүнд эзлэх татварын ачаалал жил ирэх бүр нэмэгдсээр байна.
2. Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Бүлэг-2: Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж төлөвлөөгүй, зарим төсөл, арга хэмжээ хууль тогтоомжийн шалгуурыг хангаагүй байна.

3. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, ИТХ-аар батлуулаагүй байна.
4. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

1. Аймгийн Засаг даргад:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах

Санхүү, төрийн сангийн хэлтэст:

2. Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэхдээ бодит, тооцоо судалгаанд тулгуурлах, байгууллагуудын ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийх

Аймгийн Татварын хэлтэст:

3. Жил бүр тасарч буй татварын орлогын шалтгаан нөхцөлийг тодруулж дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, татварын ногдол, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад албан ёсоор ирүүлэх